

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/043/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр аймаг
2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК
Захирал: Ж.Баяртуул
Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
Аудитор: Г.Гантуяа
Утас: 99060147, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2025. 02. 17 № 08

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502028

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>104,293,733.20</u>	<u>119,361,877.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	45,942,229.94	46,031,747.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,942,229.94	46,031,747.56
3121	Төгрөг	45,942,229.94	46,031,747.56
31211	Төрийн сангийн харилцах	45,942,229.94	42,534,013.56
31218	Ахмадын сангийн харилцах	-	3,497,734.00
33	АВЛАГА	3,341,304.41	3,341,304.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	670,365.03	670,365.05
335	Бусад авлага	2,670,939.38	2,670,939.38
3351	Байгууллагаас авах авлага	2,115,121.98	2,115,121.98
3352	Хувь хүмүүсээс авах авлага	555,817.40	555,817.40
34	УРЬДЧИЛГАА	150,000.00	150,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	150,000.00	150,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	150,000.00	150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,860,198.85	69,838,825.85
354	Хангамжийн материал	54,860,198.85	69,838,825.85
35410	Бичиг хэргийн материал	248,000.00	448,000.00
35420	Аж ахуйн материал	7,773,028.64	8,560,628.64
35460	Хүнсний материал	4,067,055.00	4,639,282.00
35470	Бусад хангамжийн материал	42,772,115.21	56,190,915.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>377,119,017.94</u>	<u>355,467,826.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	377,119,017.94	355,467,826.68
392	Биет хөрөнгө	377,119,017.94	355,467,826.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	396,197,966.24	396,197,966.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,179,994.84)	(72,160,993.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,473,343.00	50,323,243.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,350,537.37)	(38,239,078.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,554,384.93	27,554,384.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,199,039.93)	(15,390,590.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,400,000.00	4,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,000.14)	(1,980,000.18)
39217	Ном	4,762,896.05	4,762,896.05
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	582,000.00	582,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(582,000.00)	(582,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>481,412,751.14</u>	<u>474,829,704.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,194,156.77</u>	<u>2,194,156.77</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,194,156.77	2,194,156.77
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
413	Өглөг	2,194,156.77	2,194,156.77
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,194,156.77	2,194,156.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>479,218,594.37</u>	<u>472,635,547.75</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	479,218,594.37	472,635,547.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,214,677.62	59,214,677.62
51101	Өмч: - төрийн	59,214,677.62	59,214,677.62

512	Хуримтлагдсан үр дүн	223,265,514.05	216,682,467.43
51210	Өмнөх үеийн үр дүн	213,778,056.80	223,265,514.05
51220	Тайлант үеийн үр дүн	9,487,457.25	(6,583,046.62)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,738,402.70	196,738,402.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>481,412,751.14</u>	<u>474,829,704.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	384,179,659.51	516,109,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,673,159.51	8,815,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,673,159.51	8,815,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,638,159.51	8,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	12,064,359.51	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	17,573,800.00	8,000,000.00
120009	Бусад орлого	35,000.00	815,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	354,506,500.00	507,294,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	304,431,500.00	454,294,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,431,500.00	454,294,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,075,000.00	53,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,075,000.00	53,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	368,966,102.14	522,692,646.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,966,102.14	522,692,646.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	362,986,466.46	519,454,673.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,258,727.83	361,280,274.79
210101	Үндсэн цалин	123,434,867.94	217,805,910.26
210102	Нэмэгдэл	75,881,886.89	129,969,214.53
210104	Урамшуулал	7,941,973.00	13,505,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,947,910.81	46,264,805.57
210201	Тэтгэврийн даатгал	28,292,053.95	31,844,762.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,556,502.78	3,587,055.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,597,165.42	1,763,827.85
210204	Ажилгүйдлийн даатгал	642,265.85	1,763,827.85
210205	Эрүүл мэндийн даатгал	4,859,922.81	7,305,331.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,972,060.32	43,762,026.58
210301	Гэрэл, цахилгаан	4,421,612.32	4,870,162.58
210302	Түлш, халаалт	35,074,593.02	35,075,040.00
210303	Цэвэр, бохир ус	4,475,854.98	3,816,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,778,685.00	-
210401	Бичиг хэрэг	268,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	729,240.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,619,900.00	-
210408	Бараа материал акталсны зардал	6,161,045.00	-
2105	Нормативт зардал	32,581,830.50	29,388,075.00
210502	Хоол, хүнс	32,581,830.50	29,388,075.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	711,004.00	422,800.00
210604	Урсгал засвар	711,004.00	422,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	522,650.00	560,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	522,650.00	560,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,213,598.00	37,776,691.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,739,161.50	12,046,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,611,900.00	2,229,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,862,536.50	23,501,091.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,979,635.68	3,237,973.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,876,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,876,100.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,103,535.68	3,237,973.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,103,535.68	3,237,973.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,213,557.37</u>	<u>(6,583,046.62)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,726,100.12	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,726,100.12	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,726,100.12)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,487,457.25</u>	<u>(6,583,046.62)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>354,541,500.00</u>	<u>511,607,334.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	4,312,734.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	4,312,734.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,497,734.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,497,734.00
120009	Бусад орлого	35,000.00	815,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	354,506,500.00	507,294,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	304,431,500.00	454,294,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	304,431,500.00	454,294,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,075,000.00	53,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,075,000.00	53,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>338,449,049.21</u>	<u>509,667,916.38</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,449,049.21	509,667,916.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,469,413.53	506,429,942.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,059,093.38	365,314,618.38
210101	Үндсэн цалин	149,069,845.76	227,619,352.50
210102	Нэмэгдэл	64,020,774.62	123,648,835.90
210104	Урамшуулал	4,968,473.00	14,046,429.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,885,646.33	45,728,196.00
210201	Тэтгэврийн даатгал	20,468,349.38	31,061,796.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,483,047.72	3,666,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,835,900.00	1,833,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	458,299.00	1,833,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,050.23	7,333,200.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,972,060.32	43,762,026.58
210301	Гэрэл, цахилгаан	4,421,612.32	4,870,162.58
210302	Түлш, халаалт	35,074,593.02	35,075,040.00
210303	Цэвэр, бохир ус	4,475,854.98	3,816,824.00
2105	Нормативт зардал	23,316,564.50	29,960,302.00
210502	Хоол, хүнс	23,316,564.50	29,960,302.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,999,404.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	3,999,404.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	522,650.00	1,287,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	522,650.00	1,287,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,713,995.00	14,377,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,924,995.00	10,569,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,000.00	3,807,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,979,635.68	3,237,973.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,876,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,876,100.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,103,535.68	3,237,973.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,103,535.68	3,237,973.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,092,450.79</u>	<u>1,939,417.62</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,849,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,849,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,849,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,849,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(1,849,900.00)</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,092,450.79	89,517.62
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,849,779.15	45,942,229.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,942,229.94	46,031,747.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	191,918,877.63	447,871,957.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	191,918,877.63	447,871,957.95

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	21,836,392.17	21,836,392.17
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	223,265,514.05	479,218,594.37
9	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	223,265,514.05	479,218,594.37
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	223,265,514.05	479,218,594.37
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,583,046.62)	(6,583,046.62)
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.70	216,682,467.43	472,635,547.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	550,788,000.00	508,279,842.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,788,000.00	508,279,842.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	550,788,000.00	508,279,842.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,116,200.00	365,314,618.38
210101	Үндсэн цалин	261,615,100.00	227,619,352.50
210102	Нэмэгдэл	128,713,300.00	123,648,835.90
210104	Урамшуулал	9,787,800.00	14,046,429.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,177,200.00	45,728,196.00
210201	Тэтгэврийн даатгал	32,081,100.00	31,061,796.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,773,500.00	3,666,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,887,100.00	1,833,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,887,100.00	1,833,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,548,400.00	7,333,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,000,000.00	43,762,026.58
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,870,162.58
210302	Түлш, халаалт	35,000,000.00	35,075,040.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	3,816,824.00
2105	Нормативт зардал	31,519,900.00	29,960,302.00
210502	Хоол, хүнс	31,519,900.00	29,960,302.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,287,300.00	1,287,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,287,300.00	1,287,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,687,400.00	16,227,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,879,800.00	12,419,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,807,600.00	3,807,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	550,788,000.00	504,871,626.58
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	454,294,600.00	454,294,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	454,294,600.00	454,294,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,000,000.00	49,762,026.58
122005	Орон нутгийн төсвөөс	53,000,000.00	49,762,026.58
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	43,493,400.00	815,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		815,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,493,400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	45,942,229.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	42,534,013.56

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,648.7 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг завсрын аудитын явцад 3,798.8 мянган төгрөгийн 2 алдаа, жилийн эцсийн тайланд 1,849.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

- Тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын дүн мөнгөн гүйлгээний зардлын дүнгийн уялдааг шалгахад 3,798.8 мянган төгрөгийн зардлын журнал бичилт алдаатай бичсэнийг залруулсан.
- Үндсэн хөрөнгийн шинжтэй 1,849.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 7,524.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрсэнд 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитын талаар

2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар мөнгөн дүн бүхий зөрчил илрээгүй бөгөөд 1 зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу хөтөлсөн /шаардах хуудас /

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цэцэрлэгийн эрхлэгчид томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр, Боловсролын газраас ажлыг дүгнээгүй байхад Сумын засаг даргын захирамжаар 1,235.2 мянган төгрөгийн үр дүнгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

урамшуулал олгож, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 4.11-д “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмыг зөрчин олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа үндсэн бус ажилтанд /нягтлан бодогчид/ ээлжийн амралтын цалинг ажилласан хугацаанд ногдох өдрөөр бус бүтэн хоногоор тооцож 603.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84.4-т “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.” Гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн бус орон тооны ажилтанд илүү тооцож олгосон цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага өгөөгүй.

3.3 Зөвлөмж

1. Авлага, өглөгтэй холбоотой

Илрүүлэлт Он дамжсан 3,341.3 мянган төгрөгийн авлага, 150.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа, 2,194.2 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5-т “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөгийг барагдуулах зөвлөмж өгөв.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	3,8					1	3,8				
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	-						-			1	-
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	1.8					1	1.8				
Дүн	3	5.6					2	5.6			1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	5.7					1	5.7				
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	1.2	1	1.2								
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1	0.6	1	0.6								
Дүн	3	7.5	2	1.8			1	5.7				

